

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Пүрэвийн Бямба	Дугаар	L252
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Сэврэй сум
Төрсөн газар	Сэврэй сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Засаг даргын орлогч		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Цагаан суварганы хурал	Сүм хийдийн дугаар	ӨГСВ 006
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 5-р сарын 30	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Өмнөговь аймгийн Сэврэй сумын Цагаан суварганы хурал

Гантулга: За Сайхан суварганы буюу Сайн шандын хурлын талаар та товч мэдээлэл өгнө үү?

Бямба: Тэгэхээр манай энэ одоо сүмн төв байрлаж байгаа газрын урд талд одоо Цагаан суварганы хурал буюу Сайншандын хурал гэж сүмийн жижигхэн хурал байсан байгаа юм л даа. Тэгэхээр энэ хурал бол яг хэдэн онд байгуулагдсаныг нь сайн мэдэхгүй, зүгээр гол цөм цогчин дуган нь бол нэг дөчин жил болоод нуржээ гэж. Хошуундаа бол их гоё уран хийцтэй гоё дуган байсан юм гэнэ лээ гэж манай эцэг манай ахмадууд ярихдаа бол их гоё дуган байсан гэж. За энэ дөчин жил болоод буусан гэж ингэж хэлдэг юм. За түүнээс хойно гурван суварга байсан ийм учраас гурван суваргатай учраас цагаан суварга гэж. Тийм гурван сайхан суварга байсан юм гэнэ лээ. За энүүн дээр энэ ерэн оноос хойш хөөцөлдөж янз бүр болсоор байгаад энэ нутгийн ахмад одоо манай сүсэгтний зөвлөлийн дарга Аюуржунай гуай итгэл зүтгэл гаргаж энэ онд суварга босгосон. За ингээд бол ерөнхийдөө суваргыг буулгах устгах үйл ажиллагаа бол тэр гучин долоо найман онд болоод, түүнээс хойш лам нар нь татагдаад ер нь бол нэг нийтдээ дөч орчим лам нар байнга шавилан сууж байсан гэдэг юм аа. Мөн бас энд бол ер нь нэг их том Чойрын ном зааж барих нь юу байсан юм зүгээр энийг нь ч заадаг, бас тэр Төвд номынхоо сургуулийг ч бас ч гэж амжаад заадаг. Олон хүүхэд ч шавилж суудаг, арав хорин хүүхэд ч шавилж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

суудаг. Зун нь амардаг байсан гэж манай эцэг ярьдаг байсан. Ер нь дотроо товчхон жасын хийд, жастай, манж цав барьдаг. Дуган бол ер нь ойролцоо дуганаас Гоёотын хийдийн лам нар ирж бас бие биендээ харилцан хурал номоо хурдаг, ном хаялцаж энэ тэр гавжийн дамжаа барьдаг байсан гэж ингэж ярьдаг юм аа. Манай эхийн эцэг болох Гомбын Дамбадаржаа гэдэг хүн, тэр өөрөө хэлмэгдэж явахаасаа өмнө энэ хийдэд гэсгүй цолтой ажиллаж байсан гэж байгаа юм. Гэхдээ тэр энэ хурлын хийдэд шавилан сууж байгаад Гоёотын хийдэд гэсгүйн дамжаа гэдгийг барьж байсан гэж ийм юм ярьдаг. За манай өөрийн эцэг Пүрэв гэж, Аюушын Пүрэв гэж хүн байсан. За энэ хүн бас энэ хийдэд нэлээн шавилан сууж байсан. Тэгээд хувьсгалын үед бол тэр үед лам нар нь ихэнх нь татагдаад, тэгээд яахав бас гайгүй хэлмэгдэчихээгүй. Өмнөговь хүртэл явж бас хоёр гурван жил ажил хийж тэнд тэгж байгаад ирсэн. Тэгээд ирснээсээ хойш бас сонгууль болоход, бас хоёр ч удаагийн сонгууль өгөх эрх нь хасагдаж байсан гэж тийм хүн байсан л даа. Манай эцэг далан найман настай нас барсан. Тэгээд зурхайд нэлээн сайн, шар зурхай зурдаг. Ер нь зурхайн талын юм бол нэлээн мэддэг. Бас зохих хэмжээний эм барьчихдаг, төрөлх монгол хэлтэй ийм хүн байсан л даа. За тэгээд эндээс чинь одоо шууд лавлаж судалж байхад бол энэ тухайн орон нутагт бол энэ Суварганы хийдийн байж байгаа туурь, ийм ийм учиртай энэ жасын байсан байрлал туурь, тэр одоо энэ уулын Түвшин Хайрхан гэж ярьдаг, Сангийн далай хийд гэж ярьдаг тэр уул бол сангийн далай шинжтэй, түвш хэлбэртэй учраас идээ будаа элбэг байхыг бэлгэдэж тэр энгэр дээр барьсан гэж. За хойно нь хийд...

Гантулга: Харуулж барьсан тийм ээ?

Бямба: Тэр уулыг харуулж барьсан. За сүүлд нь бол нэгдэл гэж байгуулагдсан үед бол, тэр одоо энэ багийн сумын, аж ахуйн байгууллага аж ахуй нь эндээ төвлөрч цагаан идээний дан скалад байж байгаад ингээд буусан. За дуган бол буугаад энд сургууль барихад дуганы голнуудыг сургуулийн байранд зарцуулсан байдаг юм. Саяхан нэг хуучин сургуулийн байр байж байгаад буусан. Тэнд бол тийм хээтэй хуартай их гоё модууд тэр байшинд орсон байсан. Хээтэй хуартай туушийнууд их орсон байсан. За энэ Сэврэй өврийн баруун тийш арван таван км-т газар буудал гэж бий. Тэнд бол тийм сүг зураг, янз бүрийн туурь газар бий. Тэгээд тэр газар дээр нэг овоо байдаг юм. Тэгээд овооны мод нь үлдсэн байхад би нэг дуганы мод юм гэж нэг хэдэн ханз манз үсэгтэй тийм модыг аваачаад дуганы соронзог хийж аваачдаг байсан. Сонирхоод бас нэг хийдийн мод юм гэнэ лээ гээд аваачиж тавьсан. Иймэрхүү л товч түүхтэй юм даа. За миний мэдэж байгаа юм бол ийм байна. За мөн энэ хуралд сууж байсан, за Суварганы хурал, Гоёотын хурал, Дуган хурлуудад сууж байсан лам нарын за энэ суманд сууж байсан, за хэлмэгдсэн болохоор гучин найм орчим хүний нэр гарч, ус гарч тэгээд энэ талаар бас хэлмэгдэлтийн үйл ажиллагааг цэгцлээд тусламж дэмжлэг ар гэт нь олгуулах талаар судалгаа хийсэн юм байгаа юм. Арав гаран хүн авсан. За яг энэ сүмнээс бол дөрөвхөн хүн авсан, бусад нь ер нь бол ах дүү төрөл садан нь шилжээд явчихсан тодорхой мэдэх юм байхгүй тийм л байгаа. За ерөнхийдөө энэ нутагт сууж байсан нь үнэн гээд тэгээд энд амьдарч байсан ах дүү төрөл садан нь ч байдаг, тэгээд улсууд нь цагаатсан. Төрөөс олгож байгаа тэтгэмжийг авсан зүгээр ийм юмнууд л байдаг юм.

Гантулга: Та аавынхаа талаар тодруулж жоохон яриач?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бямба: Манай аав бол Аюушын Пүрэв гэж хүн байсан л даа.Тэгээд сүүлийн үед бол яахав, өнөө юм их хаалттай байлаа.Тэгээд энэ их юм хаалттай байх үед бол яахав зүгээр манай хүн бол нэг өдөр судар үзчихдэг.За жижиг гэртээ намайг хүүхэд байхад бол нууцаар цагаан сарын даллага аваад, эх нь одоо зуу нас хүрчихсэн. , Цолмонгийн Аюуш гэдэг хүн 101 насыг наслаад нас барсан өндөр настай хүн байсан.Тэгээд тэр хөгшнийг байхад бол битүүний өмнө нэг очоод гэртээ даллага хурайлга аваад, бас хөөрхөн Гомбо, Лхам бүрхан шүтдэг тийм айл байсан, тэрийгээ бас тахичихдаг тийм байсан. Тэгээд би бас сургууль соёлын ном мөр хөөгөөд цэрэг сураг гээд явчихсан.Намайг цэрэгт явсан хойно...За ирсэн хойноо бол манай эцэг ерэн оноос хойш бас цаг төр арай өөр болж, хүн амьтан бас ном судар үзэх, ийм үйл ажиллагаа явагдаж эхэлсэн.Тэгээд тэрнээс хойш нэг их удаагүйгээр нас барсан л даа.Тэгээд манай аав бол зурхайг их сайн үздэг. Хоёр төрлийн зурхай шар, хар гээд энэ хоёр зурхайг бол аль алийг нь тооцоо гаргачихдаг.Шар бичигт нэлээн сайн, Төвд бичигт бол нэлээн сайн.Бас номыг орчуулгаар нь уншчихдаг.За ямар л ном байна, бас тухайн үед нутгийн ард олон сүсэглэдэг одоо бас хамтарч ажилладаг тийм хүн байсан.Тэгээд яахав ээ, тэр юуны үед бол би бас нэг хэдэн жил мал малласан юм аа, цэрэгт явахаасаа өмнө.Тэгэхдээ яахав аавынхаа үсгийг заалгаж, төвд номноос нь бас хальт, хульт арай ч буруу харуулчихгүй шиг уншдаг болсон. Хуучин монгол бичиг заалгаж уншдаг болсон.Тийм учраас энэ түүх шашны холбогдолтой зүйлсийг сонирхдог, ийм юм. За манай эцгийг нас бараад, олон ном байсан.За би соёлын , Улаанбаатар хотын нөгөө ном авдаг соёлын сан билүү, тэнд байхад нь аваачиж өгч, за тэгээд жанрайсиг бурхныг аравнайлах сүншигний ном цуглуулах үйл ажиллагаа байсан.Тэгээд би гурван авдар ном аваачиж өгсөн. Гурван авдар бол одоогоор их том авдрууд байсан л даа .Тэгээд тэр хайрцагнуудыг ирж аваачиж өгөөд, ингээд яасан.Тэгээд ерөнхий хэрэглэж байсан зүйлүүд нь бол их юм байхгүй л дээ, надад.Бусдыг нь бол аваачаад өгчихсөн. Ийм л байна.

Гантулга: Энэ одоо Цагаан суварганы хурал гээд л байна, өөр нэрээр одоо Сайн шандын хурал гэж байсан гэсэн тийм ээ?

Бямба: Тийм.

Гантулга: Энэ нэрний учрыг ер нь түүхэн талаас нь яривал?

Бямба: За түүхэн талаас нь яривал Сайн шанд гэдэг бол усны нэр юм болов уу.

Гантулга: Усны нэр, аан за за.

Бямба: Усны нэр гэж байгаа. Баруун талдаа тэр чинь жижигхэн задгай булагтай, тэр нь Сайн гээд.Тэгээд сүүлд нь гарсан тэр гар гүн, хадан юутай тэр худгаас нь бол Сайн шанд гэсэн.

Гантулга: Тэр худгийн домогийг яривал?

Бямба: Худгийн домог бол тэр гар худаг, тэр хийдийг байгуулчихаад одоо хуралдаа ойрхон ус ууя , жаахан зайтай газраас урагшаа нэг задгай уснаас авч уудаг байсан. Ял төлбөрт орсон нэг хүн ирсэн гэж байгаа юм, дөнгөтэй. Тийм их яллуулсан хүн хүрч ирээд за лам нар , танай хийд намайг ял төлбөрөөс чөлөөлж аль , ийм учраас би та нарыг нэг амны ундааны устай болгож өгье гэж гуйдаг юм байна. Тэгээд тэр дагуу тэнд худаг үхсэн, яахав ус гаргаад өгчихдөг юм байна гэсэн.Тэгсэн хад нүдээд , царилаад ухаж гаргасан гэж байгаа юм.Тэгээд их

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

сайн үс гарсан, тэгээд лам нар тэндээс уудаг байсан.Тэр хүн ч тэгээд одоо юу гэх юм бэ дээ, тэнд тэгээд зарц ажлыг нь хийж байгаад тэгээд нас барчихсан юм гэнэ лээ.Тэгээд ийм учраас энэ худгийг гаргасан гээд , сүлийн үед дарагдчихсан байсан юм.Ер нь намайг бага ангид жаран хоёр оноос жаран таван он хүртэл энд сууж байхад бол тэндээс уудаг гол үс нь байсан.Тэгээд сүүлийн үед энэ олон түмний худаг үс гарч ирээд уухаа больсон.Тэгээд дарагдчихсан байсан нь өнгөрсөн оноос бас энэ улсууд , хөдөлмөрчид нь хүсэлт гаргасан л даа.Энэ түүхэн уламжлалтай үс юм шүү, энийг гаргая гэж тэгээд одоо сумын залуучуудын тусламжтайгаар ухаж, өнөө засаг даргын тамгын газар нэлээн хүчтэй ирсэн. Тэгээд гаргаж тохижуулаад байж байгаа үс аа.

Гантулга: Энэ хойд талын овоон дээр нэг суварга байна ш дээ. Ер нь гурван суварга байсан гэсэн, нэг нь тэр, нөгөө хоёр нь хаахнаа байсан юм бэ? Яг байршлаар нь яривал?

Бямба: За намайг... мэдэх юм бол байхгүй.Зүгээр мэдэхгүй л юм даа, нуучихсан байгаа юм.Яг тэр орой дээр нь бол гол суварга нь байсан гэж байгаа.

Гантулга: Дуулснаар бол, тийм ээ?

Бямба: Дуулснаар бол яг тэр орой дээр нь гол суварга нь байсан гэж байгаа. Тэрийг уламжлал болгож ер нь тэнд нь суварга барья гэж Хайв гуай энэ тэр ажилласан, тэгээд сумын хөдөлмөрчид нэлээн дэмжсэн.Тэгээд энэ арваад жил бараг хөөцөлдөж байж, өнгөрсөн онд бүтсэн ажил шүү дээ.За өмнө нь бол хоёр жижигхэн суварга байсан юм гэнэ лээ.Хоёр сайхан жижигхэн суварга...

Гантулга: Урд доор нь тийм ээ?

Бямба: Тийм, урд доор нь.

Гантулга: Энгэрт нь?

Бямба: Урд энгэрт нь бол дуганаас баруухан талд байсан гэдэг юм.Тэрийг сайн мэдэхгүй , зүгээр хууччуул ярьж байх нь.Энэ Хайв гуай энэ тэр ахмадууд сайн мэдэх байх.

Гантулга: Энэ үед гол дуган нь хааш хаашаа хэдий хэмжээтэй байсан, тэр үед сүүлд үлдэгдлийг нь та бол мэдэх үү?

Бямба: Зургаа найман метр байсан юм болов уу гэж бодох юм.

Гантулга: Хийсэн материал нь гэвэл?

Бямба: Материал нь дандаа хөх зөнгөөр бариад л , аа модыг нь бол дандаа хадаас ороогүй хийнэ гэж угсарч хийсэн юм гэнэ лээ.Их л гоё моднууд л энэ урд сургуулиас бүүсан ш дээ.Тэгээд ерөнхийдөө бүүлгаад тийш нь зөөж байсан.

Гантулга: Хэдий үед байгуулагдсан, хэн байгуулагдсан энэ талаар дуулсан юм?

Бямба: За би яг оныг нь сайн мэдэхгүй юм.

Гантулга: Ойролцоо сүм хийдийг нь нэрлээч, та энэ Дуганы хурал , Гоёотын гээд?

Бямба: Тийм.

Гантулга: Энэ хийдүүдийн нэр усыг өөрөөр нэрлэдэг байсан үү? Энэ талаар жоохон товч бас? Одоо сумын төвөөсөө хаашаа хэдэн км байх вэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бямба: За Дуган голын хурал бол эндээс далан тав, зургаа бол за дал орчим км бий.

Гантулга: Сумын төвөөс аль зүгт?

Бямба: Сумын төвөөсөө баруун...Зүүн хойшоо гэж байсан юм байна.

Гантулга: Тэгээд тэр байгаа газрынх нь нэр усаар яривал?

Бямба: Аа энэ Дуган гол л гэж гол байгаа юм.

Гантулга: Ар өвөрт нь уул ус?

Бямба: За үрд талдаа бол голтой, нэг ширэг устай. Тийм гол байдаг юм.

Гантулга: Дуган гол нь уу?

Бямба: Дуган гол нь байгаа юм. Ард талдаа цагаан булагтай, за ер нь тэнд яагаад байгуулсан юм гэхлээрээ энэ бас гурван гол байна. За Эрдэнэ гээд өмнө нь уул бий. Энэ бол бас эрдэмтэй, тэр уулын эрдмийг тэр усын эрдмийг тусгаж тэр энгэр дээр, очоод газар дээр нь үзэж байх юм бол ер нь юун ч одоо эвгүй газар вэ дээ гэхээр. Усны овоон дээр, хавар зуны цагт одоо ус нь яачихаж байна уу гэхээр эвгүй. Тэр намагтай газар л туурь нь байдаг юм л даа. Тэгээд ер нь яагаад ийм газар байгуулсан юм гэхлээр тэр уул ус хоёрын эрдмээс бас байгуулсан юм гэнэ лээ гэж. Яагаад гэхлээр бас энэ үеийн үе үе бас тасарч байх нь тасарч байх байх. Гэхдээ бас нэлээн нэмж суусан лам хүн бол номтой эрдэмтэй хүн л байх юм болов уу гэж тэгж шинжиж байсан гэж хүн хэлдэг юм. Одоо тэндхийн бас сайн сайн улсууд байсан л даа. Сүүлийн үед энэ Түнтэг гэж хүн бас нэлээн сайн хүн байсан л даа. Бидний мэдэх.

Гантулга: Дуганы хурлын л хүн байсан?

Бямба: Дуганы хурлын гол хүн байсан.

Гантулга: Шавилан сууж байсан?

Бямба: Шавилан сууж байсан.

Гантулга: Тэр хүний яриагаар бол тэдэн дуган байсан, тийм юм байсан гэж та мэдэх үү?

Бямба: За би бол сайн мэдэхгүй. Тэнд дуган бол хоёр ч дугантай байсан гэл үү гэж нэг таамаг байна.

Гантулга: Одоо энэ туурь нь бол хэр зэрэг том байх үү?

Бямба: Бага аа, багын хувьд бага. Багавтархан юм бий.

Гантулга: Энэ нөгөө Гоёотын хурлын тухай яривал?

Бямба: Гоёотын хурлыг бол би сайн мэдэхгүй ээ.

Гантулга: Ерөөсөө мэдэхгүй юу?

Бямба: Мэдэхгүй.

Гантулга: Уг нь бол танай нутагт хуучин харъяанд байж байгаад?

Бямба: Ер нь бол Сэврэй харъяанд байж байгаад тасархай болсон юм.

Гантулга: Хуучин засаг захиргааны нэгжээр ингэж яривал, Түшээт хан аймгийн гэж явах үү? Эргэн тойрон танай сум чинь?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бямба: Манай энэ баруун урагшаа бол түрүүхэндээ Чүлтэм гүн гээд л , сүүлд нь Балдан засгийн хошуу гээд л...Тэгээд л одоо хувьсгалаас хойш бол Говь Гурван сайхан уулын хошуу гээд л .Гурван Баяндалай, Булган, тэгээд Гурвантэс Сэврэй энэ бол нэг хошуу.

Гантулга: Эргэн тойрон одоо тийм тийм хошуу нутагтай залгаа байсан гэж яривал?

Бямба: За хойшоо Ламын гэгээн.Баянхонгорын Ламын гэгээн байна.За зүүн тийшээ тэгээд л юу билээ, тэд нар л байна.

Гантулга:Тэгээд одоо хөгшчүүлийн ярьж байгаагаар бол том эрдэмтэй номтой ид шидтэй лам бороо орохгүй ган болоод байвал ингэж байсан, өвчин хижиг гараад байвал ингэж байсан тийм хутагт хувилгаан эндээс төрсөн улсуудын талаар дурсвал?

Бямба: За манай хошууны Жал гэгээн гэж бол нэлээн хошууны алдартай гэгээн байсан.

Гантулга: Одоо энэ Суварганы хурлын юу?

Бямба: За ерөнхийдөө нэг Суварганы хуралд ч байсан нь юу юм.Тэр Байшинтын хийд, Гурвансайханд байж байгаад Дээд хийд гэж байсан юм.Тэр газар нутгаар нутаглаж байсан гэж.Одоо хойд дүр нь гээд энэ өвөр Далайн ийшээ л байж дээ. Тэр хүн энэ Хүрмэн гарлын чигийн ах дүү нь ч байдаг гэж.Жал гэгээн бол бүр номтой эрдэмтэй, үе уламжлан дүр тодруулдаг тийм хүн байсан гэж.

Гантулга: Жал гэгээн гэж?

Бямба: Манай энэ ойролцоо бол Өндөр гэгээн Хөнөө өвөг гэж, янз янзын улсууд бас нэрлэдэг юм аа улсууд.

Гантулга: Энэ улсуудын одоо тийм ид шид үзүүлж байсан гээд ард түмний дунд үлдсэн түүх домог гэвэл?

Бямба: За байдаг л юм, одоо...

Гантулга: Ганц нэгээс нь яривал?

Бямба: Жишээ нь тэр Охины өвгөн гэдэг бол их мэргэн зэргэн хүн байсан юм гэнэ лээ.Одоохон тэгэх гэж байна, шөнө одоо унтаж байгаад гэнэт босоод ном уншаад унадаг, яав гэхээр тэр айлын нэг тийм хүн нь өвдөөд зовоод төрөх гээд байна.Тэгсэн тэр нь яг л таарч байдаг.Хүн жишээ нь одоо очоод цай хадаг бариад, эм барьдаг хүн байж л дээ.За очоод нэг эм залаад ирье, уулзах гэж байгаа гэхлээр нь цайг нь буудал булчихаад хадгийг нь аваачиж өгөөд эм залаад ирээрэй гэсэн өө тийм үү хүү минь гээд хадгийг нь авчихаад за чи минь бушуухан явахгүй бол цайг чинь үхэр бороонд норгочихно шүү гэж хэлж байсан гэдэг. Тэр нь тэгээд буудалд булчихсаныг нь үхэр малтаж гаргасан байсан гэдэг юм.Тиймэрхүү яг бодитой юмнууд бол байдаг л юм.

Гантулга: Одоо энэ хийдин туурин дээрээс бол таныг залуу байхад бол хийдийн нурсан барьсан байгуулаймжийг одоо барилгын материалыг нь харж байхад одоо ямар гоё юм бэ гэхээр одоо тоосго цөн нь хээ хуартай тийм юм бас байсан уу, та мэдэж байсан уу?

Бямба: Байсан.

Гантулга: Ямар ямар...?

Бямба: Яг тэг дөрвөлжин, хааш хаашаа тэг дөрвөлжин голоороо нүхтэй номын үсэгтэй тийм юмнууд бол байдаг л байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тоосгон?

Бямба: Тоосгон хавтангууд. За тэр намайг сургуульд байж байхад бол сая бид нар очлоо ш дээ, хийдийн ус.Түүнээс цааш байгаа нэг овгор шороон дотор бас нэг дуурианы ч гэх юм уу, тухайн эриний ч гэх юм уу шар гуулин бурхны хүний дүрстэй гар хөл энэ тэр л байсан юм. Өөр одоо тодорхой мэдэх юм алга.Ер нь ном суварга олон байсан шүтээнүүдийнх нь талаар юм хэлдэггүй юм.

Гантулга: Танай хошуу хуучин хаана төвлөрч байсан юм, хошуу тамгын газар нь?

Бямба: Хошуу тамгын газар нь Цагаан дэрс гэдэг газар байсан юм гэнэ лээ.

Гантулга: Одоо эндээс хаашаа?

Бямба: Одоо эндээс Баяндалайн нутагт л байна. Зүүн зүгт.

Гантулга: Хошуу хурал энэ тэр гэж...?

Бямба: Хошуу хурал нь тэр дээд хурал байсан юм гэнэ лээ.

Гантулга: Дээд гэж...?

Бямба: Майхны энгэрт байгаа.

Гантулга: Одоо эндээс яривал ямар газар байна яг?

Бямба:Аан?

Гантулга: Одоо яг Зүүн сайхан уулын?

Бямба: Зүүн сайхан уулын баруун ард л тэр Дүнгэнээгийн ам гэдэгт байгаа.

Гантулга: Тэгээд одоо энэ хурал хийдүүдийн аль нэг нь ахлана ч гэдэг юм уу одоо, тэргүүлдэг арай том нь ч гэсэн юм уу тийм мэдээ байвал?

Бямба: Байшинтын хийд, Дээд хурал хоёр л байсан юм гэнэ лээ.Миний сонсноор бол.

Гантулга:Сүүлд хэлмэгдэлтийн үед ингээд лам нарыг хэлмэгдүүлсэн тухай дуулж байсан юм, одоо лам нарыг яаж барьж яаж байсан, одоо судар ном шүтээнийг нь тийшээ авч явсан гэдэг юм уу , устгаж шатаасан гэдэг юм уу тэр талаар мэдээ дуулсан юм байвал?

Бямба: За ер нь тодорхой юм алга даа.Зүгээр янз янзаар л ярьдаг юм шүү дээ. Зүгээр яг одоо бодитой нь юу байдаг юм.Зүгээр манай эхийн ярьснаар бол тэр манай эцгийг баривчилахад тэр Ёндон гэж хүн байсан.Тэр авч явж байгаад энэ Ноёны ард нас барчихсан юм гэнэ лээ.За мөн эхийн дүү тэр Гомбын Дамбадаржаа гэдэг хүнийг баривчилахад мөн барьж авч явсан гэдэг юм.За би тэгж баривчилахад есөн настай байсан гэж байгаа юм.За би мэдэхгүй л дээ, манай эх есөн настай байсан гэж байсан гэж байхгүй юу.Биш ээ, тэр би есөн настай манай эх бол намайг гаргачихсан, хорин долоотой билүү байсан байх.Тэгээд тэр ингэсэн гэж байгаа юм аа.Би бас сайн мэдэхгүй юм аа тэрийг.Юм хурааж байхыг нь бол мэддэг юм , одоо энэ манайхны л байхгүй болж л дээ.Жамсран гэдэг айл, тэднийтэй нэг айл хамт туугаад явдаг.Тэгээд тэр мал хурааж байхыг нь би мэдэх юм, муухан мэдэх юм.Тэгээд тэр юу ч үгүй л авдаг байсан юм, хотонд миний нэг эрхлүүлдэг хонь байсан юм, тэгээд би тэрийг хүзүүдээд зогсоод байсан, бусад малыг туугаад л явсан. Яаж байгаа, юу болж байгааг мэддэггүй.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Одоо энэ Цагаан суварганы хурал гэдэг юм уу, хэдэн энэ хийдүүдийн эргэн тойронд байгаа тахилгатай газар усны нэрийг нэрлэвэл, тахилгатай уул овоо?

Бямба: Чүр хайрхан байна.За тэгээд энэ Зөөлөнд байна, Хашаат гэж тахилгатай уул байна. Баян борнуурууд маань ингэж нэрлэдэг, Хашаат гэж. Ийм гурван тахилгатай өндөр уул ус бий дээ, ер нь ерэн оноос хойш...

Гантулга: Зүг чигээр нь , сумын төвөөс тийшээ, ийшээ гээд?

Бямба: Өө сумын төвөөс зүүн тийшээ тэр Хашаат гэж байгаа, зүүн хойшоогоо байгаа юм аа. Хоолтын нутагт.За баруун хойно чиг л орно доо.Норовбанзад гэж за Баянсүмбэр гэж.Тахилгатай уулыг нь бол Дашноров гэж нэрлэдэг.

Гантулга: Тэр баруун хойшоогоо одоо тахих гээд байгаа уул чинь ямар уул билээ?

Бямба: Тэр Дашноров, Сэврэй хайрхны .

Гантулга: Энэ уулынх нь одоо тахилганы судар, одоо уламжилж ирсэн тийм судар, ном нь бий юу?

Бямба: Байхгүй байна аа. Ерөөсөө олдохгүй байна.Бас Хайв гуай бид хоёр нэлээн хөөцөлдсөн.Тэгээд хэд хэдэн хүнээс сурахад цагаан өвгөний цам байсан юм билээ гэж.За намдагсан уншиж байсан юм шиг байна.За тэгээд л Дашзэвэгийн сан, ийм л номууд, аа арван хангал уншиж байсан юм гэнэ лээ. Өвөл орой арван гурван сан тавьж байсан юм гэнэ лээ гэж ийм ийм юм байдаг юм.За ерөнхийдөө Хайв гуай баахан юм цуглуулсан байсан.Тэгээд манай эцэг бас намайг нэг дагуулаад ууланд гарч байсан л даа.Нууцаар энэ нутагт байсан тэр Даржаа гэдэг хүн, за мөн одоо энэ хэн гэж байсан юм...Долгорсүрэн гэж хүн байсан юм.Тэгээд энэ энэ тэр бол очиж л байсан.Тэгэхэд бол тэр би ч анзаарахгүй л дээ.Ямар ном уншиж байгаа юм мэдэхгүй.Нэг арц эд нар цуглуулж янз бүрийн туслах ажил хийж байсан юм, морь мал харж.Тэгээд нэг уулан дээр очиж баахан ном уншчихаад явж байсан. Тэгээд л сүүлд нь асууж байхнээ тэр хангал , дашзэвэгийн сан, тэр намдагсан эд нарыг л уншиж байсан юм гэнэ лээ, цагаан өвгөний цам.Тэгээд яг Сэврэй хайрхны сан гэж байсан л байлгүй.Тэрийг нь бол би одоо мэдэхгүй байна.

Гантулга: Савдаг, сахиус нь тийм савдагтай сахиустай байсан гэж мэдэхгүй юу?

Бямба: Ер нь домгоор бол Жамсран сахиус гэж, одоо энэ уулыг бол шинжилдэг Жамсран сахиус юм аа л гэж.Жамсрангийн одоо энэ догшин бурхан учраас энэ улаан ямаагийн нь алах юм бол мөн ч хэцүү дээ бас гэж ярьдаг хөөрдөг л байсан юм гэнэ лээ.Тэгээд ар хүрээ дээр нь уулын ард огторгуй ус гэж байсан.Огторгуйн ус гэдэг бол дарагдаад он удаан жил болсон.Тэгээд тэр жил бас нэг хэдэн хөгшчүүл, өвгөчүүл би бас энэ бригадын дарга нэлээн хэдэн жил хийсэн.Тэгээд бас гаргая гэж нэлээн үзсэн.Тэгээд бас болоогүй л юм байгаа юм.Тэгээд ам мамыг нь заалгаж авч л байсан.Тэгээд бас өдөртэй судартай, ёстой төртэй авах гээд Хайв гуай тэгж байсан, тэгээд тэгж байсан юм аа.Тэгээд гараагүй.

Гантулга: Тэр цагаан суварганы туурин дээр чинь бас нэг хүрдний суурь байсан. Тэрний тухай бас нэг домог?

Бямба: Аа тийм.

Гантулга: Тэр хүрдний суурийг?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бямба: Тэр хүрдний суурин дээр чинь ерөөсөө тийм том ганц хүрд байсан юм гэнэ лээ. Аа том эргүүлдэг хүрд. Тийм хүрдтэй, тэгээд тэр хүрдэн дээр нь одоо ямар, тэр үеийн л нэг зөрчил байх л даа. Тэр хүрдийг авч хаячихаад, хонхор хийгээд тэгээд шавар эмчилгээ, баруунтаа ууланд байдаг Нэмэлтийн рашаан гэж бий л дээ. Тэндээс рашаан авчраад мөн шавар авчраад, тэгээд нөгөө хөлийн бие хаа элэг цөсөнд сайн гэж гишгүүлдэг тийм оруулдаг хонхорхой байсан юм. Тэгээд сүүлд нь тийм нэг юу босгосон юм, дугуй хүрээ. Энд нэг ийм юм байсан юм шүү гэж тэмдэг тавьж нэг тийм цементэн гортиг татаж...

Гантулга: Тэр баруун хойд талд нь нэг бас овоотой нэг овоо байна ш дээ, Бумбат...?

Бямба: Аа Бумбан шар гээд.

Гантулга: Тэрний түүх?

Бямба: Аа тэрийг би сайн мэдэхгүй юм аа. Түүхийг нь мэдэхгүй юм. Зүгээр манай нэг эцэг ярьж байсан юм. Тэр баруунтаа байгаа Сайншандын ус гэж байгаа юм. Тэр ч яахав ээ бас, хоёр гурван жилийн өмнө их ширүүн бороо орж үерт огт байхгүй болчихсон байсан юм. Одоо гарсан юм. За тэгээд тэнд байгаа л даа. Нэг жаахан задгай ус байгаа юм. Элэг цөсөнд сайн гэж уулын наад энгэрээс урсаж байгаа юм л даа. Тэндээсээ улсууд их авч уудаг л байсан юм, тэгээд улсууд уудаг. Тэгээд би боддог юм аа, зүгээр урагшаа хараад хэвтэж байгаа нохой шинжтэй уул аа гэж. Тэгээд би боддог байсан юм аа зүгээр, өмнө нь бойны барилга бариулаад, энэ нөгөө нэгдэл гэж байхад чинь улсын нэгтгэлийн олон мянган малыг нядалдаг байлаа. Тэгэхээр нохой шинжтэй юм болохоороо тэр шинжээ дагаж, тэгэхэд манай эцэг байсан л даа. Тэгээд л одоо энэ л тэдэн мянган мал нядална, бригадаас тэдэн мянган мал гаргана гээд ярьж байдаг байхгүй юу. Аа тэр чинь нохойны аманд аваачиж хийж байгаа хэрэг дээ. Уул нь нохой шинжтэй юм гэж би ярьдаг юм. За одоо тэр үнэн байх аа, Хайваа гуайгаас тодруулаарай. Тэгээд тэрүүнийг номхотгох гэж яахав нохой янз бүрийн юманд догшроод байж магадгүй юм гээд тэр үеийнхээ одоо сүсэг бишрэлийн үүднээс байдаг юм уу, тэр уулыг одоо бас Бунхан гэж цол хэргэм өгөөд тахиж шүтэж бас тэгж аргадаж байсан юм гэнэ лээ.

Гантулга: Аа нэрийг нь сольж?

Бямба: Нэрийг нь сольж. Урьд нь ямар шар гэж байсан гэлээ. Бас нэг тийм юм ярьдаг юм.

Гантулга: За ярилцлага өгсөн танд баярлалаа.

Бямба: За зүгээр.

Гантулга: Хадан дээр бичиг үсэгтэй тийм газар хаана байдаг вэ?

Бямба: За энэ сумаас одоо зүүн зүгт Цагаан чулуу гэж хөшөө бий. Нарангийн Цагаан чулуу хөшөө гэж хөшөө бий. Тэр хөшөө одоо Тогоон Төмөр хааны үеийн холбогдолтой хөшөө юм шиг байгаа юм. Тэнд бол тийм тэр хавьд байдаггүй боржигон чулуу бий. Ер нь манай энэ хавьд тийм чулуу байхгүй. Үнэхээр одоо тухайн үедээ Тогоон төмөр хаан энд буудаллаж байсан юм гэнэ лээ гэж ярьдаг. За мөн Шилийн зурвасын тэмдэг байж магадгүй гэсэн нэг таамаг байдаг. Тээр жил түүхийн хүрээлэнгийн хэдэн улсууд ирээд энэ сумын нарийн бичиг Жадамбаа гэж хүн байсан юм. За тэр хүнтэй, тэгээд бид нар байсан. Цуг очоод үзэж байсан. Шинжилгээний улсууд тэгж ингэж ирээд үзэж байхдаа бол Туркийн үеийн холбогдолтой юм шиг байна аа гэж.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Түрэгийн үеийн?

Бямба: Түрэгийн үеийн холбогдолтой бичиг байна аа. Энэ бас холбогдолтой сайхан дурсгалтай юм байна аа гэж ингэж ярьдаг нэг ийм чулуу бий. За ер нь энэ чулуу бол хажуу тийшээ ооччихсон юм аа. Тэгээд сүүлийн үед бол энэ босгоод янзалчихсан л даа.

Гантулга: Дээрээ бичиг үсэгтэй юу?

Бямба: Байгаа. Тэгэхдээ зүгээр бас улсуудын миний сонссон домгоор бол энэ чулуу бичгээрээ харж оочих юм бол монголд сайн юм гэнэ лээ. Гэдрэгээрээ харж оочих юм бол Хятадад сайн юм гэнэ лээ гэж нэг домог байдаг л даа. Гэхдээ хэлтийж оочсон гэж аль аль талдаа дундаж л байх нь гэж тэгж ярьдаг байсан. Одоо бол тэр чинь тийм юм байхгүй, хаашаа оочсон нь хамаагүй тэгээд л хүн босгоод тавьчихна.

Гантулга: Ер нь хэдий хэмжээтэй чулуу бол?

Бямба: Чулуу бол за хэрийн хүн өргөчихгүй дээ, хааш хаашаа нэг метр элбэг жаахан мохчихсон тийм чулуу бий.

Гантулга: Одоо Монгол Төвд бичээстэй тийм хад гэвэл?

Бямба: Монгол Төвд үсэг бичээстэй хад гэвэл Нуурсамаатын зүүн тийш тэр Жаргалантын хөндийд...

Гантулга: Хэдий орчим зайд?

Бямба: Сумаас нэг хорин тав билүү, хорин тав арай хүрэхгүй байх аа. За дөхөм нэг хорь орчим км-т. Хаа хөндийн тийм зураг бий. Бас нэлээн, тэнд бол тийм ханз үсгүүд л байдаг юм даа. За Төвд үсэг ч байдаг юм аа. Соёмбо үсгийн хэлбэртэй үсэгнүүд байдаг юм билээ. Би бас үзэж байсан. Мөн цаашаа Хоолтын нутагт байгаа юм. Тэр далан таван км ээ Хоолт баг. Хоолт багаасаа баруухан хойшихноо Баян-Овоо гэж газар бий. Тэнд бол хадны бичиг зургууд их бий. За тэнд бол Маанийн үсгүүд бий. За бас бусад үсгүүдийг нэлээн товойлгоод хийчихсэн. Ийм сайхан дурсгалтай. Бас л түүхийн холбогдолтой байх гэж бодож байна. За Сэврэйгээс баруун тийшээ арван тав, зургаан км-т Харын үзүүр гэж хадны сүг зураг бүхий. За мөн энд ч бас нэлээн жуулчид ч ирдэг юм. Ер нь манай түүхийн нэг номонд ч орсон байх юм билээ, зураг хөрөг нь. Олон амьтны сүг зураг, олон сайхан хад бий. Тэнд ч одоо Төвд үсэг байхгүй ээ. Цаашаа нэг хорин таван км-т Зааргын хар овоо гэж хөндий бий, гаазр бий. Тэрүүний хөндийд монгол бичгээр бичсэн, хуучин монгол бичиг уйгаржин бичгээр, за мөн Төвд үсгээр бичсэн номын үсэг, хадан дээрх бичээс бий.

Гантулга: За ярилцлага өгсөнд маш их баярлалаа.

Бямба: За баярлалаа та бүхний энэ түүхийн холбогдолтой одоо түүхээ мэдэх гэсэн олон зуун жилийн турш өв уламжлагдаж ирсэн шашин төрийн ёс дэглэмийг сайн мэдэж эргэн сэргээх одоо түүхийн холбогдолтой зүйлүүдийг яваа та нөхдөд одоо их баярлалаа. Ажил үйлс чинь сэтгэлчлэн бүтэж сайн сайхан явахыг л хүсэх байна.

Гантулга: За баярлалаа.